


# ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ НЭГДСЭН БҮРТГЭЛИЙН САН

## СИСТЕМД ХАНДАХ ЛИНК

http://hr.hdc.gov.mn/




# **Хүний нөөцийн хөгжлийн систем** – хэрэглэгчийн гарын авлага

## БҮРТГЭЛ ҮҮСГЭХ

Системд хандах линк:

http://hr.hdc.gov.mn/

**Бүртгэлтэй хэрэглэгч:**

Хэрэв өмнө нь бүртгүүлчихсэн бол "Нэвтрэх нэр"- хэсэгт регистрийн дугаар

"Нууц үг" – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

**Бүртгүүлэх** товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж заавартай танилцана уу /Нэвтэрсний дараа "Тусламж" цэснээс бусад заавартай танилцаарай/

# БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

1. http://hr.hdc.gov.mn/ хаягаар нэвтэрч "Бүртгүүлэх" дарж бүртгүүлнэ /бүртгэлтэй бол дахин бүртгүүлэхгүй/
2. "Регистрийн дугаар", "Эцэг эхийн нэр", "Өөрийн нэр", "Утасны дугаар", "И-мэйл хаяг" /хувийн ашиглагддаг хаягаа оруулах-нууц үг сэргээх мэдэгдэл очиход ашиглагдах тул алдаагүй зөв бичсэн байх/, "нууц үг", "нууц үг баталгаажуулах" /өөрийн мартахгүй байх нууц үг зохиож үүсгэнэ/ талбарыг Монгол хэлээр алдаагүй бөглөж, "үйлчилгээний нөхцөл" хэсгийг чагталсны дараа БҮРТГҮҮЛЭХ товчийг дарж бүртгүүлнэ.
3. НЭВТРЭХ товчлуур дарж Нэвтрэх нэр-Өөрийн регистер, Нууц үг- өөрийн зохиосон нууц үгийг бичиж программд нэвтрэнэ.
4. Баруун дээд хэсэгт байх өөрийн нэр дээр дарж "Миний мэдээлэл" хэсгийг сонгож нээнэ.
5. "Ерөнхий мэдээлэл" хэсэгт байх "Мэдээлэл шинэчлэх" товчийг дарснаар таны мэдээлэл ХУР системээс баталгаажин ногоон өнгөтэй болно. /Жич: овог нэрийг алдаатай эсвэл латинаар бичсэн, бичиж дуусаад зай авсан тохиолдолд баталгаажихгүй/
6. Програмд дахин нэвтрэн орж бөглөгдөөгүй талбарын мэдээллийг бүрэн бөглөнө. /цээж зураг хэсэгт албан хувцастай эгц өөдөөс харсан зураг оруулна/
7. "Мэргэжил" гэсэн цонхыг дарж "Мэргэжил", "Дипломын дугаар", "Тушаалын огноо"/захирлын тушаал/, "Зардлын хэлбэр", "Төгссөн сургууль" зэргийг сонгож хавсралт хэсэгт өөрийн дипломыг дунгийн хавсралтын хамт **PDF** хэлбэрээр оруулж хадгална. /Монгол тал байхад болно/
8. Үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтаа мөн адил талбар бүрийн ард байх **+ товч** дарж бөглөнө.
9. Ажлын туршлагаа бөглөж, нотлох баримыг PDF-ээр хавсаргана /Өмнөх ажилласан туршлагаа бүрэн оруулна/
10. Таны ажлын туршлагыг танай ажил олгогч байгууллагын хүний нөөц баталгаажуулах үүрэгтэй.
11. Уг бүртгэл нь зөвхөн нэг удаа үүсгэх бөгөөд цаашид өөрчлөлтийн мэдээллээ оруулаад явна.
12. "Ерөнхий мэдээлэл", "Мэргэжил", "Ажлын туршлага", "Боловсрол", "Мэргэжлийн зэрэг", "Сургалт", "Дүйцүүлэх материал" хэсэгт өөрийн мэдээллээ бүрэн бөглөөрэй.

**Бүртгэл үүсгэх дэлгэрэнгүй заавартай танилцаарай**

# Зөвлөгөө

- Заврын дагуу бүртгэлээ үүсгэн Системд нэвтэрсний дараа **Тусламж** хэсгээс бусад заавартай танилцана.
- Зөвхөн бүртгэл үүсгэснээр Шалгалтад орох, Лицензийн хүсэлт илгээх, Сургалтад **хамрагдах боломжгүй.** Иймд авах үйлчилгээний заавар **Тусламж** хэсгээс бүрэн уншиж танилцаад шалгалт, лиценз, сургалтын хүсэлтээ илгээнэ үү.
- Мэргэжил хэсэгт эзэмшсэн мэргэжил, мэргэшил, Ажлын туршлага хэсэгт албан тушаалаа **бөглөсөн тохиолдолд програм ажиллаж** эхлэнэ.
- **Нууц үг сэргээхэд и-мэйлд хариу ирэхгүй тохиолдолд:** credit@hdc.gov.mn и-майлд зөвхөн өөрийн и-майл хаягаас /yahoo-аас бусад/ НУУЦ ҮГ СЭРГЭЭХ гэж бичээд Овог, Нэр, Регистр, Ургийн овог, Утас, Оршин суугаа Аймаг/хот/, Сум/дүүрэг/, Баг/хороо, Хаягаа илгээнэ. Мэдээллээ илгээсэн таны нэртэй и-мэйл хаяг, нууц үгээ сэргээж авах хаяг болно. Имайл хаягаа солиулсны дараа та өөрөө нууц үгээ сэргээж авна.
- **Байгууллага шинээр бүртгүүлэх:** Ажлын туршлага бүртгүүлэхэд танай байгууллага програмд байхгүй тохиолдолд credit@hdc.gov.mn и-майлд БАЙГУУЛЛАГА БҮРТГҮҮЛЭХ гэж бичээд байгууллагын регистр, тусламж үйлчилгээний чиглэлээ бичиж, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг илгээнэ.
- **Ажилтнаа баталгаажуулах хүний нөөцийн эрх авах:** Хүний нөөцийн ажилтан өөрийн бүртгэлийг үүсгэн ажлын туршлага хэсэгт томилогдсон тушаалаа хавсаргасны дараа credit@hdc.gov.mn и-мэйлд БАЙГУУЛЛАГЫН ЭРХ АВАХ гэж бичээд байгууллагын регистр, өөрийн регистрийн дугаарыг илгээнэ. Хүний нөөцгүй тохиолдолд байгууллагын удирдлага буюу эзэмшигч болохоо нотолсон /улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, дүрмээс өөрийн нэр орсон аль нэгийг/ бичиг баримтаа програмын өөрийн ажлын туршлагад хавсаргана.

# Хэрэглэгч - Системд бүртгүүлэх




**1.** Иргэншил: Сонгох

**3.** Эцэг/эхийн нэр: Овог оруулах

**4.** Өөрийн нэр: Хэрэглэгчийн нэр

**5.** Утасны дугаар: Тоогоор оруулах

**6.** Имейл хаяг: Нууц үг солих, мэдээлэл илгээх тул заавал зөв хаяг оруулах

**8.** Үйлчилгээний нөхцөл зөвшөөрөх : Үйлчилгээний нөхцөлтэй танилцаад **Зөвшөөрсөн** тэмдэглэгээтэй болгох.

**2. Регистрийн дугаар:**
Регистрийн дугаар оруулна.

**Нэвтрэх нэр нь цаашид регистр байна.**

**7. Нууц үг :**
5-с дээш орон бүхий тоо, үсэг, тэмдэгт оролцуулан үүсгэх
**Нууц үг баталгаажуулах:**
Үүсгэсэн нууц үгийг давтан оруулна

9. "**Бүртгүүлэх**" товч дарснаар бүртгэл амжилттай болсныг харуулах цонхонд шилжилнэ.

# Системд бүртгүүлэх – **Амжилттай бүртгэгдлээ !**




1. Таны бүртгэл амжилттай болсон бол зураг дээрх хуудас харагдана.

**Системд нэвтрэх нэр**
Таны бүртгүүлсэн регистрын дугаар нь системд нэвтрэх нэр болохыг анхаарна уу!

Нэвтрэх нэр нь цаашид **регистрийн дугаар** байна.

"**Нэвтрэх**" товч дарж нэвтрэх хуудсанд шилжилнэ үү.

# Хэрэглэгч - Системд нэвтрэх







**Зураг1**

**1.** Нэвтрэх нэр: Бүртгүүлэхдээ оруулсан таны **регистр**

**2.** Нууц үг:
- Өмнө бүртгүүлсэн бол таны үүсгэсэн нууц үг
- Энэ програмд бүртгүүлээгүй бол 12 гэсэн нууц үгийг оруулах

"**Нэвтрэх**" товч дарснаар системд нэвтэрнэ.

**зураг2**

**Амжилттай** нэвтэрсэн бол та дээрхи зурагт харуулсан хуудсанд шилжсэн байх болно.

*Хэрвээ нэвтэрч чадаагүй бол хэрхэн нууц үг сэргээх тухай дараагийн хуудсанд тайлбар оруулав.*

# Хэрэглэгч - Нууц үгээ мартсан, Нууц үг сэргээх




hr.hdc.gov.mn

Системд нэвтэрч чадаагүй бол **Зураг 1-т** харуулсан Анхааруулга харагдана.
-Та нэвтрэх нэр (регистрийн дугаар), нууц үгээ шалгаад дахин оролдоно уу.

Регистрийн үсгийг крилл үсгээр бичсэн байна.

Таны зохиосон нууц үг

Та нууц үгээ мартсан бол **“Нууц үг сэргээх”** товч дарж регистр, и-мэйл хаяг оруулж и-мэйлээр шинэ нууц үгээ авна уу







Амжилтгүй бол

**Үүнийг унш**

YAHOO тус програмтай хамтран ажиллахгүй байгаа тул Yahoo хаягнаас бусад өөрийн солиулах и-майл хаягнаас credit@hdc.gov.mn хаягт өөрийн Овог, Нэр, Регистр, Утас, И-мэйл, Ургийн овог, Оршин суугаа Аймаг/хот/, Сум/дүүрэг/, Баг/хороо/, Хаягаа илгээн и-майл хаягаа шинэчлүүлэн нууц үгээ өөрөө сэргээж авна.

зураг2
1. Регистрийн дугаар:
   Бүртгүүлэхдээ оруулсан таны **регистр**
2. И-мейл хаяг:
   Бүртгүүлэхдээ оруулсан **и-майл** хаяг

**Амжилттай** гэж гарсан бол таны и-майл хаягруу нууц үг илгээгдэнэ. Ирээгүй бол **Spam, Junk, Promotion**-оо шалгана. Мөн и-майлийн санах ой дүүрсэн эсэхийг нягтлана уу.

# Амжилттай нэвтэрлээ – **Миний мэдээлэл**




**Компьютерээс хувийн мэдээлэл оруулах**

**1.** Баруун буланд харагдах өөрийн нэр дээр дарах

**2.** Миний мэдээлэл цэс дээр дарснаар миний мэдээлэл хуудсанд шилжинэ

**Гар утас, бусад хэрэгслээс хувийн мэдээлэл оруулах**

**3.** тэмдэг дээр дарах

**4.** тэмдэг дээр дарж миний мэдээлэл цэсийг сонгон Миний мэдээлэл хуудаст шилжинэ




### Мэдээлэл цэс:

Системд нэвтэрсэн хэрэглэгч системтэй холбоотой асуулт асуух, бусад хэрэглэгч нарын оруулсан мэдээллийг харах боломтой.

### Зарлал цэс:

Өөрт хамаарах, шалгалт, сургалт, ажлын зар бусад мэдээлэлтэй танилцана.

### Тусламж цэс:

Програмыг ашиглах, бүх төрлийн үйлчилгээнд хамрагдах зааврууддтай танилцана.

# **Миний мэдээлэл –** Хурын мэдээлэл баталгаажуулах



# Миний мэдээлэл – Ерөнхий мэдээлэл

**1.** Гэрийн хаяг:
Аймаг/Нийслэл сонгох
Сум/Дүүрэг сонгох
Баг/Хороо сонгох
Гэрийн хаяг хэсэгт Хашаа/Байр, тоот хаяг бичиж оруулах.

**2.** Ургийн овог :
Өөрийн ургийн овгийг оруулах

**3.** Нууц үг солих :
Нууц үгийг солих цэсийг идэвхижүүлэн, доорхи зурагт харуулсан талбаруудыг бөглөж **солих** товчийг дарснаар нууц үгийг сольно.




**4.** Гэр бүлийн мэдээлэл: - нэмэх товч дарж мэдээлэл оруулах хүснэгт үүсгээд харгалзах баганад утгуудыг бөглөх.

**5.** Та өөрчлөлт хийсэн, мэдээллээ оруулсан бол **ХАДГАЛАХ** товч дарна уу.







-Регистрийн дугаар улаан хүрээтэй бол мэдээлэл шинэчлэх товчыг дарна уу. Таны мэдээлэл баталгаажсаны дараа **Хадгалах** товч гарч ирнэ.

# Миний мэдээлэл – Мэргэжил | мэргэжил нэмэх




**1.** Мэргэжил, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын харгалзах [+] - товчийг дараад **Зураг2**-т харуулсан цонх нээгдэх ба харгалзах утгуудыг бөглөж, сонгоод Хадгалах дарснаар мэргэжил нэмэгдэнэ.




**зураг2**

**2.** Мэргэжил: Эзэмшсэн мэргэжлээ сонгох
Тушаалын дугаар : Тушаалын дугаар оруулах /*заавал биш*/
**3.** Тушаалын огноо: Тушаал гарсан огноог оруулах
**4.** Зардлын хэлбэр: Хувийн | Улсын | Төсөл, хөтөлрийн гэсэн 3н сонголтоос сонгох
**5.** Суралцсан улс: Мэргэжил эзэмшсэн улсаа сонгох.
**6.** Байгууллага: Байгууллага сонгох /хэрэв гадаадад мэргэжил эзэмшсэн бол бичиж оруулах боломжтой./
**7.** Хавсралт: Таны мэргэжлийн зэргийг нотлох хуулбар баримтыг PDF-ээр оруулах.
**8.** дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

Бөглөсөн мэдээллийн дагуу зөвхөн таны мэргэжил, мэргэшилтэй хамааралтай мэдээлэл харагдах тул мэргэшсэн байдлаа бүрэн бөглөнө үү

# **Миний мэдээлэл –** Мэргэжил | мэргэжил нэмсэн


Б.Батням

Мэдээлэл

Зарлал

Тусламж

Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

Мэргэжил

| Мэргэжил | Дипломын дугаар | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Төгссөн сургууль, байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хүний их эмч | D200012568 | 2387 | 2000-06-11 | Монгол | АШУҮИС-ийн харъяа Анагаахын их сургууль | Хувийн | |

Үндсэн мэргэшил

| Үндсэн мэргэшил | Дипломын дугаар | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Дотрын анагаах судлал | S(r)091210/2020/78 | 587 | 2002-11-15 | Монгол | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Хувийн | |

Төрөлжсөн мэргэшил

| Төрөлжсөн мэргэшил | Дипломын дугаар | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бөөр судлал | S(r)098910/2020/78 | 5100 | 2004-11-15 | Монгол | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Хувийн | |

Дэд мэргэшил

| Дэд мэргэшил | Дипломын дугаар | Тушаалын дугаар | Огноо | Суралцсан улс | Байгууллага | Зардлын хэлбэр | Хавсралт |
|---|---|---|---|---|---|---|---|
| Яаралтай тусламж судлал | Sr-2002156 | 509 | 2021-11-15 | Монгол | Цэргийн төв эмнэлэг | Хувийн | |

Мэргэжил хэсэгт оруулсан мэдээллээс хамааран програм танд тохирох мэдээллийг харуулах тул Боловсрол хэсэгт мэргэжлийн мэдээллээ бөглөсөн ч гэсэн үйлчилгээ авахын тулд энэ Мэргэжил хэсгийн мэдээллийг заавал бөглөнө.

Зөвхөн их эмч үндсэн мэргэшил эзэмшдэг тул бусад ажилтнууд үндсэн мэргэшил хэсгийг бөглөхгүй байхыг хүсье.

# **Миний мэдээлэл –** Ажлын туршлага | Ажлын туршлага нэмэх




Програмд танай байгууллага байхгүй тохиолдолд хүний нөөцийн ажилтныг Тусламж хэсгээс Хүний нөөцийн заавартай танилцуулна уу.

Хүний нөөцийн ажилтан таны байгууллагын мэдээллийг зөвшөөрч **БАТАЛГААЖСАН** тэмдэглэгээ үүссэнээр та програмд бүртгэлтэй болно.

Алба, нэгжийн мэдээллийг танай байгууллагын хүний нөөцийн ажилтан үүсгэх тул мэдээлэл дутуу тохиолдолд Хүний нөөцийн ажилтандаа хандана уу.




**Ажлын туршлага бүртгэх**

**+** тэмдэг дээр дарснаар ажлын туршлага бөглөх цонх нээгдэнэ. Та ажлын туршлагаа бөглөн **Хадгалах** товчийг дарна уу.

Файл хавсаргах дээр ажилд орсон тушаал зэрэг бичиг баримтаа хавсарган хадгалах боломжтой.

# **Миний мэдээлэл –** Боловсрол, Лиценз, Зэрэг

Боловсрол




| Улс | Сургуулийн нэр | Мэргэжил | Зэрэг | Диплом дугаар | Элссэн огноо | Төгссөн огноо | Хамгаалсан сэдэв | Хавсралт | + |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль | Эрүүл мэндийн нийгмийн ажилтан | Анагаах ухааны магистр /MSc/ | 2140300 | 2023-10-24 | 2023-10-24 | Нийгмийн эрүүл мэнд | | |

Хураас татсан мэдээлэл

| Сургуулийн нэр | Боловсролын зэрэг | Мэргэжил/Хөтөлбөр | Төгссөн жил |
|---|---|---|---|
| Ашуүис /Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль/ | Бакалаврын зэрэг | Нийгмийн Эрүүл Мэнд | 2022 |

Боловсролын мэдээлэл нь ХУР системээс татагдана, хэрэв системд ороогүй тохиолдолд **+** дарж хавсаргах боломжтой.

Энэ хэсэгт боловсролын зэрэг цолоо оруулах бөгөөд мэргэжлийн мэдээллийг "Мэргэжил" хэсэгт бөглөх ёстойг сануулж байна.

Лиценз




| Лицензийн дугаар | Лицензийн төрөл | Сунгасан төрөл | Хүчинтэй хугацаа эхлэх | Хүчинтэй хугацаа дуусах | Тушаалын дугаар | Төлөв | Тэмдэгтийн хураамж | Зөвшөөрөл түдгэлзүүлэх үндэслэл | Түүх |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ИЭ0019929 | Уламжлалт анагаах ухааны их эмч | Шалгалт | 2017-06-07 | 2022-06-07 | 236 | ХҮЧИНГҮЙ | | | ТҮҮХ ХАРАХ |
| 3444 | Уламжлалт анагаах ухааны их эмч | Багц цаг | 2022-07-06 | 2027-07-06 | А/356 | ХҮЧИНТЭЙ | | 8.0 КРЕДИТ | ТҮҮХ ХАРАХ |

Лиценз шалгах дарж хүчинтэй болон өмнөх зөвшөөрлийн мэдээллээ хараарай.

Хэрэв таны хүчинтэй лиценз харагдахгүй бол [credit@hdc.gov.mn](mailto:credit@hdc.gov.mn) майлд хүчинтэй лицензийн зургаа илгээж зөвшөөрлийн сангаас лавлагаа аваарай.

Зэрэг




Системийн бус зэрэг

| Мэргэшлийн зэрэг | Гэрчилгээний № | Зэрэг хамгаалсан чиглэл | Хамгаалсан он | Хавсралт | Баталгаажилт | + |
|---|---|---|---|---|---|---|
| Ахлах | 0007614/2017-10 | Нүүр амны сувилахуй судлал | 2017-10-02 | | | |

Системийн зэрэг

| Мэргэшлийн зэрэг | Чиглэл | Хүсэлтийн төрөл | Гэрчилгээний № | Хүчинтэй хугацаа эхлэх | Хүчинтэй хугацаа дуусах | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|
| Тэргүүлэх | Сувилагч | Шинээр горилох | 436 | 2023-10-06 | 2028-10-06 | ХҮЧИНТЭЙ ТҮҮХ ХАРАХ |

Мэргэжлийн зэрэг 2024 оноос хойш цахимаар олгож эхэлсэн тул өмнөх зэргийн гэрчилгээгээ Системийн бус зэрэг хэсэгт оруулаарай.

# **Миний мэдээлэл –** Сургалт

Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

Сургалтын мэдээлэл татах

Системийн бус сургалт

| Улс | Байгууллага | Сургалтын нэр | Сургалтын төрөл | Эхэлсэн хугацаа | Дууссан хугацаа | Кредит | Хавсралт | + |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол | Оточ манрамба их сургууль | Ханиур засал, түүний онол арга зүй | Багц цагийн сургалт | 2017-10-14 | 2017-10-14 | 1 | | |
| Монгол | Этүгэн их сургууль | Зүрх судасны зонхилон тохиолдох өвчний орчин үеийн оношилгоо эмчилгээний чиг хандлага | Багц цагийн сургалт | 2017-10-21 | 2017-10-21 | 2 | | |
| Бүгд Найрамдах Хятад Ард Улс | Шинжлэх ухаан технологийн яам, Олон улсын харилцааны газар | Mongolian medicine professional Training course | Багц цагийн сургалт | 2023-01-03 | 2023-01-16 | 4 | | |

Системийн сургалт

| Байгууллага | Сургалтын нэр | Сургалтын төрөл | Сургалтын дэд төрөл | Сургалтын хэлбэр/цахим, танхим/ | Эхэлсэн хугацаа | Дууссан хугацаа | Кредит | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТЭЖЭЭХҮЙ УХААН | Уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчин судлал | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн сургалт | | 2022/08/27 10:00 | 2022/08/27 18:00 | 2 | АМЖИЛТТАЙ |
| Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Яаралтай тусламж /бага эмч/ - 2023 намар | Дээшлүүлэх сургалт | Эмнэлзүйн сургалт | Танхимын сургалт | 2023/10/09 00:00 | 2023/12/15 00:00 | 8 | ТАТГАЛЗСАН |
| Эм зүйн шинжлэх ухааны их сургууль | Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний оношилгоо, эмчилгээ | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн бус сургалт | Танхимын сургалт | 2023/10/28 08:00 | 2023/10/28 17:59 | 1.0 | ХҮЛЭЭН АВСАН |
| Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Дотрын өвчний зонхилон тохиолдох эмгэгүүд | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн бус сургалт | Танхимын сургалт | 2023/12/01 09:00 | 2023/12/01 17:00 | 1 | ХҮЛЭЭН АВААГҮЙ |

**surgalt.hdc.gov.mn програмаар багц цаг бүрдүүлсэн тохиолдолд таны мэргэжлийн чиглэлд тохирсон сургалт бол мэдээлэл татах дээр дарахад багц цаг тань нэмэгдэж орно**

2020 оноос өмнөх багц цагийн мэдээлэл орно. Зөвшөөрөл сунгахад ашиглагдсан сургалтын мэдээлэл дахин ашиглагдах боломжгүйгээр ингэж түгжигдэнэ

Гадаад сургалтын мэдээллээ оруулж, засварлаж болно. Цэнхэр үзэг нь ашиглагдаагүй багц болохыг илтгэнэ.

Амжилттай суралцсан сургалтын мэдээллийг зөвшөөрлөө сунгуулахад ашиглах боломжтой болно

Сургалт эрхлэгч байгууллага таны хувийн мэдээлэлтэй танилцаад сургалтад суулгахаас татгалзах эрхтэй

Таны хүсэлтийг хүлээн авсан тул товлосон хугацаандаа сургалтдаа сууж ирцээ бүртгүүлээрэй

Таны сургалтад суух хүсэлтийг хүлээн аваагүй байгаа тул Сургалт явуулсан байгууллагатай холбогдоно уу
Таны сургалтад суух хүсэлтийг хүлээн авалгүй, ирц хангалтгүй гэж үзэн сургалтыг дуусгасан бол багц цаг нөхөж авах боломжгүй

# Миний мэдээлэл – Сургалт| Багц цагийн гэрчилгээ оруулах







## Өмнө хамрагдсан системийн бус сургалт системд оруулах

1. **Нэмэх** товч дарах /**Зураг 2**-т харуулсан цонх нээгдэнэ./
2. Суралцсан улс: Суралцсан улсаа сонгоно.
3. Байгууллага: Улс нь монгол бол дотоодын сургалтын байгуулагаас сонгоно. /Гадаад бол бол өөрөө бичих боломжтой/
4. Сургалтын нэр: Суралцсан сургалтын нэрээ бичиж оруулна.
5. Сургалтын кредит: Тоон утгаар оруулах
6. Үндсэн мэргэжил
   Төрөлжсөн мэргэжил
   Дэшлүүлэх : Тухайн сургалт мэргэшлийн аль чиглэлд багтах болохыг тодотгоно.
7. Сургалтын хугацаа: Сургалт эхэлсэн, дууссан хугацааг сонгож оруулна.
8. Тайлбар: Шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар оруулах боломжтой /заавал биш/
9. Хавсралт: Сургалт амжилттай дүүргэсэн гэрчилгээ, материалыг хавсралтаар зураг эсвэл PDF-ээр оруулна.
   дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл хадгалагдана.

# Миний мэдээлэл – Гишүүнчлэл




**Гишүүнчлэл хэсгийг зөвхөн мэргэжлийн зэргийн шалгалтад орох тохиолдолд бөглөнө.** Энэхүү хэсэг нь тухайн хүний олон нийтийн байгууллагад гишүүнчлэлтэй эсэхтэй хамааралгүй болно.

Та өөрийн мэргэжлийн чиглэлийн дагуу горилох гэж буй мэргэжлийн зэргийг тань олгох эрх бүхий зөвхөн ганц мэргэжлийн нийгэмлэг, холбоо, Мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүнчлэлийг сонгоорой.

Энэ нүхийг зөвлөснөөр нийгэмлэг, холбоо, Мэргэжлийн салбар зөвлөлийн эрх бүхий этгээдэд өөрийн мэдээлэлтэй танилцах, засах, устгах эрх олгож байгаа тул мэргэжлийн зэрэг горилох шалгалтад орсноос бусад тохиолдолд зөвлөсөн тэмдэглэгээг арилган Мэдээллээ хаахыг анхаарна уу.

Тухайн байгууллагын мэргэжлийн зэрэг олгох эрхтэй чиглэлүүдийн жагсаалтыг эндээс харна

# Миний мэдээлэл – Шалгалт



Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

Системийн бус шалгалт

| Шалгалтын нэр | Төрөл | Дэд төрөл | Авсан оноо | Босго оноо | Тэнцсэн эсэх | Огноо | Хавсралт | + |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Мэргэшлийн зэргийн шалгалт ахлах зэрэг шинэээр горилох | Мэргэшлийн зэргийн шалгалт - Ахлах | | 80.0 | 60.0 | Тийм | 2023-08-01 | | |

Системийн шалгалт

| Шалгалтын нэр | Төрөл | Дэд төрөл | Авсан оноо | Босго оноо | Тэнцсэн эсэх | Огноо | Төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|
| Мэргэшлийн зэргийн шалгалт 2023 Эм зүйч-Ахлах (шинээр горилох) | Мэргэшлийн зэргийн шалгалт - Ахлах | | 85.0 | 80.0 | Тийм | 2023-06-19 10:00 | |
| 2023.09.15-ны Эм зүйчийн шалгалт | Зөвшөөрлийн шалгалт - Ажиллагсад | Эм зүйч | 85.0 | 70.0 | Тийм | 2023-09-15 10:00 | Төлбөр төлсөн |

**Шалгалт хэсэгт таны оролцсон зөвшөөрөл, элсэлт, төгсөлт, мэргэжлийн зэргийн шалгалтын түүх хадгалагдан үлдэх болно.**

Системийн бус дүнг эрх бүхий байгууллагаас таны мэдээлэлд нэмж оруулах боломжтой.

Тус програмаар шалгалтын төлбөрөө төлсөн тохиолдолд хүсэлт баталгаажих бөгөөд энэ хэсгээс шалгалтдаа нэвтэрч орж болдог.

# **Миний мэдээлэл –** Дүйцүүлэх материал




**Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө багц цаг, тайлангаар сунгуулах, мэргэжлийн зэрэг хамгаалах ажилтнууд дүйцүүлэх материал хэсгийг ашиглана.**

Мэдээллүүдээ үнэн зөвөөр нотлох баримтын хамт оруулж **Хадгалах** товч дарснаар таны мэдээлэл програмд хадгалагдан, хүсэлт илгээхэд ашиглагдах боломжтой болно.

Дүйцүүлэх материал оруулахдаа хавсаргасан Материалын нэршилээ зөв сонгохыг хүсье

# **Миний мэдээлэл –** Ажлын туршлага | Нийгмийн даатгалын мэдээлэл харах




**Нийгмийн даатгал төлөлт**

1. Шаардлагатай хугацаагаа тохируулан нийгмийн даатгалын төлөлтийн мэдээлэлтэйгээ танилцаж болно.
2. Хянах эрх бүхий ажилтан таны ажлын туршлагыг Нийгмийн даатгал төлөлтөөр баталгаажуулан хянах боломжтой.
3. Ажилтанд мэдээлэл мөнгөн дүнтэйгээ харагдах бол хянах эрх бүхий бүх ажилтанд цалин, шимтгэл мөр харагдахгүй.



# Заавартай бүрэн танилцсан танд баярлалаа

## ЦАХИМ ФЛАТФОРМ БАТАЛГААЖСАН МЭДЭЭЛЭЛ

[www.hr.hdc.gov.mn](http://www.hr.hdc.gov.mn)